



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

┌Жуулчны мэдээллийн төв байгуулах тухай ┐

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн 2.2.6, нийслэлийн Засаг Даргын 2015 оны А/198 дугаар захирамжаар батлагдсан "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай захирамж, тус газрын дүрмийн 2.3, 2.7, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлд аялал жуулчлал хөгжүүлэх, гадаадын иргэд жуулчдад Улаанбаатар хот, аялал жуулчлалын бусад бүсүүдийн талаар хэрэгцээт мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Жуулчны мэдээллийн төвийг Сүхбаатар дүүргийн Сөүлийн гудамж дахь Улаанбаатар хотын цагдаагийн газрын Иргэдэд үйлчлэх төвийн 1 дүгээр давхарт байгуулан 2015 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн ажиллуулахыг Мэдээлэл сурталчилгааны төвийн менежер Д.Энхбаярт даалгасугай.


2. Жуулчны мэдээллийн төв байгуулах төсвийг хавсралт ёсоор баталж, шаардагдах 20,951,427 /хорин сая есөн зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун хорин долоон/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2015 оны 05 сарын 11-ний
өдрийн 138 тоот тушаалын хавсралт



СӨҮЛИЙН ГУДАМЖИД УЛААНБААТАР ХОТЫН ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН
САЛБАР БАЙГУУЛАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2015 оны 5 дүгээр сарын 11

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Хянасан
1	Тохижилтын зардал /ширээ, шүүгээ, тавиур, гэрэлтүүлэг багтсан/	-	4 630 000	4 630 000	
2	Ус цэвэршүүлэгч	1	150 000	150 000	
3	Иж бүрэн компьютер	2	1 200 000	2 400 000	
4	Хувилагч, өнгөт принтер	1	340 000	340 000	
5	LED Зурагт 40 инч	1	850 000	850 000	
6	Улаанбаатар хотын газрын зураг	1	250 000	250 000	
7	Мэдээллийн ажилтны цалингийн зардал /ТҮ-7, ур чадварын нэмэгдэл 25% хүртэл/	12	722 618,9	8 671 427	
8	Улаанбаатар төмөр замын төв буудал дахь Жуулчны мэдээллийн төвийн байрны түрээс	12	300 000	3 600 000	
9	Бичиг хэргийн зардал /бичгийн хэрэгсэл/	1	60 000	60 000	
Нийт				20,951,427	

Боловсруулсан: НАЖГ-ын Мэдээлэл сурталчилгааны

төвийн менежер

Танилцсан: Ахлах нягтлан бодогч

Д.Энхбаяр

П.Ариунаа